



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/200

Есөнбулаг

Хичээл сургалтын үйл ажиллагаанд  
зохицуулалт хийх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн ихэнх сумдын цаг агаар, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэн, малчдын мал төллөх үе тохиож, салхин цэцэг, томуу, томуу төст өвчний тохиолдлын тоо нэмэгдэж байгаа зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч байгаатай холбогдуулан аймгийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын 2023-2024 оны хичээлийн жилийн гуравдугаар улирлын танхимын хичээл, сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөр дуусгавар болгон сурагчдын улирлын амралтын хугацааг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл амрахаар зохицуулахыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т даалгасугай.

2. 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 03 дугаар сарын 29-ний өдрийг хүртэлх тав хоногийн хичээл, сургалтыг хичээлийн жилийн дөрөвдүгээр улиралд зайн, цахим болон бусад хэлбэрээр нөхөн зохион байгуулахыг аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар), Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

